



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/553

Булган сум

Гадаад албан томилолтын зардал
гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XI/03 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр”, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай” А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өргөдөл гомдол, нийтийн мэдээллийн ил тод байдал, цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Д.Наранбаярыг Бүгд найрамдах Солонгос улсад 2025 оны 08 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд “Төрийн албан хаагчдын бүс нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх” нь сэдэвт сургалтад хамрагдахад шаардлагатай албан томилолтын зардал гаргасугай.

2.Албан томилолтын зардалд шаардагдах 4,527,684 (дөрвөн сая таван зуун хорин долоо мянга зургаан зуун наян дөрөв) төгрөгийг аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн зардлаас гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010765

Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 22-ийн өдрийн 455 дугаар захирамжийн хавсралт



“Төрийн албан хаагчдын бүс нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх” нь сэдэвт сургалтын томилолтын задаргаа

№	Гадаад улсын 1 өдрийн томилолтын зардал	Валютын ханш	Нийт өдөр	Нийт дүн /төгрөгөөр/
	1	2	3	4
1	210\$	3593,40	6	4.527.684